

МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 1/549


Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн тавдугаар хуралдааны 5/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баруун бүсийн даншиг наадмыг зохион байгуулах стадион, наадмын талбай засварлах зардалд 9,700,000 төгрөг (есөн сая долоон зуун мянга)-ийг зарцуулсугай.
2. Дээрх зардлыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 5/07 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт, аймгийн их засварын хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 3.1 "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн өвөлжилтийн бэлтгэл хангах, болзошгүй эрсдэлийн зардал" арга хэмжээнээс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх), Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт зөвшөөрсүгэй.
3. Дээрх засварын ажлыг хуульд нийцүүлэн түргэн шуурхай зохион байгуулахыг Чандмань сумын Засаг дарга (З.Онолбаатар)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГ



Т.ДЭЛГЭРСАЙХАН

8400 01 2636  
Zah A/549 tum